



## НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 03 сарын 19 өдөр

Дугаар А/30

Улаанбаатар хот

### Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Авилгын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Мэдээллийн ил тод байдал болон мэдээлэл авах эрхийн тухай хууль, Монгол Улсын Их Хурлын 2016 оны 51 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2016 оны 10 дугаар сарын 26-ны А/752 дугаар захирамжаар батлагдсан Газрын дүрмийн 2.5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын 2018 оны Авилгын эсрэг төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.
2. Төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хугацаанд нь бүрэн хэрэгжүүлэхийг хэлтсийн дарга нар болон нийт албан хаагчдад үүрэг болгосугай.
3. Төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс /С.Оюунцэцэг/-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.ГҮНДСАМБУУ

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын  
даргын 2018 оны 03 дугаар сарын 19-ны өдрийн  
А/20 дугаар тушаалын хавсралт



**НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН  
2018 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

2018 оны 03 дугаар  
сарын 19 -ний өдөр

Улаанбаатар хот

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Бүтээгдэхүүн	Хугацаа, хуваарь	Хариуцах/ Хамтран хэрэгжүүлэх хэлтэс
<b>Үндэсний хөтөлбөрийн заалт: 4.1.1. Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх, ёс зүйг дээшлүүлэх</b>				
1	Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх зорилтыг хангах чиглэлээр дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:	<ol style="list-style-type: none"> <li>1. Албан тушаал, ажлын байрны тодорхойлолт, хариуцсан ажил үүргийн талаарх мэдээллийг иргэд олон нийтэд нээлттэй байлгах.</li> <li>2. Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллах.</li> <li>3. Засгийн газрын 2011 оны 62 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн үүргийг түр орлон гүйцэтгэх журам”-ын хэрэгжилтийг хангаж ажиллах.</li> <li>4. Авлигаас урьдчилан сэргийлэх, хувийн ашиг сонирхол болон хөрөнгө орлогын мэдүүлгийг үнэн зөв мэдүүлэх тухай сургалт зохион байгуулах.</li> <li>5. Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг, хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд гаргах, бүртгэл хөтлөх.</li> <li>6. Албан хаагчдад хууль болон Засгийн газраас зөвшөөрсөн давхар ажил эрхлэхтэй холбоотой мэдээлэл өгөх, давхар ажил эрхэлж буй албан тушаалтны бүртгэл хөтлөх.</li> </ol>	Жилдээ	ЗСХ/ЭБАТ

		7. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйл 11.2 дахь заалтыг хэрэгжүүлэх.		
		1. Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг мөрдүүлж, хяналт тавих. 2. Ёс зүйг дээшлүүлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө батлаж, биелэлтийг хангаж ажиллах. 3. Ёс зүйн зөрчлийн талаар мэдээлэл хүлээн авах нөхцлийг бүрдүүлэх, цахим хуудаст байршуулах. 4. Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн албан хаагчид хариуцлага тооцох, зөрчлийн талаарх бүртгэл хийх.	Жилдээ	Ёс зүйн хороо
		5. Төрийн болон байгууллагын нууцаас хамааруулснаас бусад удирдлагаас гаргаж буй шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах, албаны цахим хуудас болон нутгийн захиргааны байгууллагуудын шийдвэрийн нэгдсэн санд оруулах, мэдээллийн самбар, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээлэх. 6. Дунд, богино хугацааны стратеги төлөвлөгөө, Төсвийн шууд захирагчийн үр дүнгийн гэрээ, Байгууллагын дүрмээр хүлээсэн чиг үүргийн биелэлт, үр дүнг цахим хуудсаар дамжуулан олон нийтэд нээлттэй мэдээлэх.	Тухай бүрт	МТХ/ХХ
<b>Үндэсний хөтөлбөрийн заалт: 4.1.2. Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, хүртээмж, үр ашгийг нэмэгдүүлэх</b>				
2	Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлэх, чанар хүртээмжийг нь сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:	1. Байгууллагын цахим хуудас болон мэдээллийн төрөл, агуулгыг төрийн байгууллагын цахим хуудаст тавигдах шаардлагад нийцүүлэх.	Тухай бүрт	МТХ
		2. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, журмын дагуу хөрөнгө оруулалт, худалдан авалтын ажлын зорилго, үр дүнг олон нийтэд сурталчлан ажиллах.	Тогтмол	ХААХ/ Нийт албан хаагч
		3. Худалдан авах ажиллагааны ил тод, нээлттэй байдлын хэрэгжилтэд хууль, журмын дагуу	Хагас жилд	ЗСХ/ Хяналт, шинжилгээ,

		<p>хяналт, шинжилгээ үнэлгээ хийж, гүйцэтгэлийг сайжруулж ажиллах.</p> <p>4. Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэл, үр дүнд хяналт, шинжилгээ үнэлгээ хийж, гүйцэтгэлийг сайжруулахад анхаарч ажиллах.</p>	нэг удаа	үнэлгээний асуудал хариуцсан албан хаагч
		5. Шилэн дансны тухай хууль, Шилэн дансны цахим хуудаст тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журмыг хэрэгжүүлэн ажиллана.	Тухай бүр	ЗСХ/ ЭБАТ
<b>Үндэсний хөтөлбөрийн заалт: 4.1.3. Төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, хариуцлагыг дээшлүүлэх</b>				
3	Төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:	<p>1. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай, хэмнэлттэй зарцуулж, аливаа өр, авлага үүсгэхгүй хэмнэлтийн горимыг чанд сахих.</p> <p>2. Байгууллагын санхүүгийн анхан шатны баримтын бүрдлийг хангаж нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, УИХ, Засгийн газар, Сангийн сайдын баталсан холбогдох заавар, журмыг мөрдөж ажиллах.</p> <p>3. Санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн дүгнэлтээр гарсан зөрчил, дутагдлыг дахин гаргахгүй байх.</p> <p>4. Шилэн дансны тухай хууль, Шилэн дансны цахим хуудаст тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журмыг хэрэгжүүлэн ажиллана.</p>	Жилдээ	ЗСХ/ Ахлах нягтлан бодогч
<b>Үндэсний хөтөлбөрийн заалт: 4.1.4. Худалдан авах ажиллагааны хяналт, хариуцлага, үр ашгийг нэмэгдүүлэх</b>				
4	Худалдан авах ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, үр ашигтай, шударга, ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлж, хяналт, хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр дараахь	1. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн урилга, тендерийн баримт бичиг, хяналтын төсөв, зураг төсөв холбогдох материал болон тендерийн нээлтийн мэдээлэл, сонгон шалгаруулалтын үр дүнг доорх цахим системүүдэд зохих шаардлагын дагуу нийтлэж, тендерт оролцогч аж ахуйн нэгж, иргэдийг бүрэн мэдээллээр хангах. Үүнд:	Тухай бүр	ХААХ/ Үнэлгээний хорооны нарийн бичгийн даргаар томилогдсон албан хаагч

	үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:	<ul style="list-style-type: none"> <li>a. Худалдан авах ажиллагааны цахим систем <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>,</li> <li>b. Байгууллагын цахим хуудас <a href="http://www.ub-procurement.mn">www.ub-procurement.mn</a>,</li> <li>c. Нийслэлийн дундын мэдээллийн цахим хуудас <a href="http://www.open.ulaanbaatar.mn">www.open.ulaanbaatar.mn</a>-д</li> </ul>		
		<ul style="list-style-type: none"> <li>2. Худалдан авах ажиллагаа зохион байгуулахад зарцуулж буй хугацааны бүртгэл хөтөлж, дундаж хугацааг бууруулахад чиглэсэн зохион байгуулалтын ажлыг хийх.</li> <li>3. Эрх бүхий байгууллагаас зөрчилтэй дүгнэлт авсан буюу дахин зарлах, дахин үнэлгээ хийх, тендерийн баримт бичигт өөрчлөлт оруулж дахин зарлахаар шийдвэрлэгдсэн ажлын бүртгэл үүсгэж, тоог бууруулах арга хэмжээ авч ажиллах.</li> <li>4. Худалдан авах ажиллагаатай холбоотой үүссэн гомдлын бүртгэл хөтлөн, судалгаа хийж, тоог бууруулах талаар арга хэмжээ авч ажиллах.</li> </ul>	Улирал бүр	ХААХ
		<ul style="list-style-type: none"> <li>5. Тендерийн баримт бичгийг батлагдсан даруйд лацдах.</li> </ul>	Тухай бүр	ЗСХ
		<ul style="list-style-type: none"> <li>6. Тендерийн баримт бичгийн лацны бүртгэл хөтөлсөн байх.</li> </ul>	Тухай бүр	ЗСХ/ Нярав
		<ul style="list-style-type: none"> <li>7. Үнэлгээний хорооны гишүүдээр ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг тухай бүрт гаргуулах, хяналт тавих, цахим хуудаст байршуулах.</li> </ul>	Тухай бүр	ЗСХ/ ЭБАТ
<b>Үндэсний хөтөлбөрийн заалт: 4.1.7. Иргэний нийгмийн байгууллагын идэвх санаачилга, оролцоог дэмжих</b>				
5	Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналт, иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлэн, идэвх санаачилгыг дэмжих зорилтыг хангах чиглэлээр дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:	<ul style="list-style-type: none"> <li>1. Худалдан авах ажиллагаанд иргэн, олон нийтийн төлөөллөөр хяналт тавин ажиллах эрх бүхий иргэн, олон нийтийн төлөөллийн тоог нэмэгдүүлэх.</li> <li>2. Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд ажиллаж буй иргэн, олон нийтийн төлөөлөлд цагийн бүртгэлийг үндэслэн 2014 оны 212 дугаар тушаалаар батлагдсан “Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг</li> </ul>	Жилдээ	МТХ

		зохицуулах журам"-д заасны дагуу ТҮ-7 нэгдүгээр шатлалын нэг цагийн цалинтай тэнцэх хэмжээ буюу 3156 төгрөгийн урамшуулал хөлс олгож ажиллах.		
<b>Үндэсний хөтөлбөрийн заалт: 4.1.10. Авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх</b>				
6	Шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэн, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:	<ol style="list-style-type: none"> <li>1. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль холбогдох хууль тогтоомжийг сурталчлан сургалт зохион байгуулах.</li> <li>2. Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэх эрсдлийг бууруулах, урьдчилан сэргийлэх зорилгоор худалдан авах ажиллагааны процесс дахь ашиг сонирхол, авлигын эрсдлийг үнэлж, авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан, биелэлтийг хангах.</li> <li>3. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх хүсэл эрмэлзлээ илэрхийлэх, уриалах арга хэмжээг зохион байгуулах.</li> </ol>	Жилдээ	ЗСХ/ ЭБАТ
<b>Авлигатай тэмцэх газрын зөвлөмжийн заалт: Худалдан авах ажиллагааны тогтолцоог сайжруулах</b>				
	Зөвлөмж 1: Худалдан авах ажиллагааны бодлого, төлөвлөлт оновчтой бус, ил тод байдал хангалтгүй, гүйцэтгэлд тавих хяналт сул, хариуцлага тооцох эрх зүйн орчин боловсронгуй бус байгаа нь авлигын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчил үүсэн нөхцөл бүрдүүлж байгаад онцгой анхаарах, Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөрийн 4.1.4.1, 4.1.4.2, 4.1.1.3-д тусгасан үйл ажиллагааг эрчимтэй хэрэгжүүлэх.	<ol style="list-style-type: none"> <li>1. Тендер шалгаруулалтын талаар гарсан гомдлын шийдвэр дүгнэлтийг олон нийтэд ил тод болгох.</li> <li>2. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд Төсвийн ерөнхийлөн захирагчийн тухайн онд хэрэгжүүлэх худалдан авах ажиллагааг бүрэн нэгтгэж, багц, задаргаа тус бүрээр ойлгомжтой хэлбэрээр олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлэх.</li> </ol>	Тухай бүр	ХХ/ МТХ
	Зөвлөмж 2: Гэрээний үүргээ биелүүлээгүй, хугацаа хоцроосон	1. Тендерийн баримт бичгийг хуурамчаар үйлдэн ирүүлсэн оролцогчийг хар жагсаалтад оруулахаар	Тухай бүр	ХААХ/ Үнэлгээний

хуулийн этгээдэд хариуцлага тооцох үр дүнтэй механизмыг бий болгох, энэ чиглэлээр холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах.	эрх бүхий байгууллагад тухай бүр баримтжуулан хүргүүлэх.		хорооны нарийн бичгийн даргаар томилогдсон албан хаагч
Зөвлөмж 3: Худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн албан хаагчдын тоог нэмэгдүүлэх, тэднийг сургах, чадавхижуулах, тендерийн үнэлгээний хороог байнгын бус ажиллагаатай байхаар зохион байгуулах, үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд мэргэжлийн холбоод, иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг оролцуулах, тэдгээрийн хяналт тавих нөхцлийг бүрдүүлэх.	<ol style="list-style-type: none"> <li>1. Нийт албан хаагчдыг худалдан авах ажиллагааны АЗ гэрчилгээ эзэмшүүлсэн байх.</li> <li>2. Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд ажиллаж буй иргэн, олон нийтийн байгууллагын төлөөллийн тоог нэмэгдүүлэх.</li> <li>3. Иргэн, олон нийтийн төлөөлөлд үнэлгээний хорооны үйл ажиллагаатай хууль, журмын талаарх мэдээлэл, танилцуулга хийх, мэдээллийн самбар хийж хурлын танхимд байршуулах.</li> </ol>	Жилдээ	МТХ
Зөвлөмж 4: Тендерийн баримтын бүрдүүлэлт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, худалдан авах ажиллагаа хариуцсан ажилтан, үнэлгээний хорооны гишүүдийн ёс зүй, хариуцлагыг чангатгах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах.	<ol style="list-style-type: none"> <li>1. Тендерийн баримтын бүрдүүлэлтийн иж бүрэн байдлын хангасан эсэхэд хяналт шалгалт хийсний үндсэн дээр акт үйлдэж архивын мэргэжилтэнд хүлээлгэн өгөх.</li> <li>2. Үнэлгээний хорооны гишүүдийн ёс зүй, хариуцлагын талаар тусгайлан сургалт зохион байгуулах.</li> </ol>	-Гэрээ байгуулагдсан өдрөөс хойш 28 хоногийн дотор -1 дүгээр улиралд	ХААХ/ ЭБАТ
Зөвлөмж 5: Улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжих хөрөнгө оруулалтын шинжтэй томоохон бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг худалдан авах үйл ажиллагааны мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэхэд чиглэсэн арга хэмжээг авах, цаашид энэ асуудлыг эрхлэх Засгийн газрын агентлаг байгуулах талаар судалж, шийдвэрлэх.	<ol style="list-style-type: none"> <li>1. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад хэрэгжиж буй худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулах чиглэлээр заавар, зөвлөмж гаргаж хүргүүлэх.</li> <li>2. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын хүсэлтээр үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд мэргэжлийн байгууллагын төлөөллөөр ажиллаж, хууль, журмын хэрэгжилтийг хангуулах.</li> </ol>	-2 дугаар улиралд -Тухай бүр	ХААХ/ ЗСХ/ ХХ
Зөвлөмж 6: Худалдан авах	1. Нийслэлийн Засаг даргаас эрх шилжүүлсэн	-Тухай бүр	

	<p>ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахим хэлбэрт шилжүүлэх. Ялангуяа төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн худалдан авах ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэхэд онцгойлон анхаарах.</p>	<p>худалдан авах ажиллагааг төрийн худалдан авах ажиллагааны цахим систем <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> – ээр дамжуулан цахим хэлбэрээр зохион байгуулах.</p> <p>2. Нийслэлийн харьяа төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн худалдан авах ажиллагааны цахим системийн ашиглалтын талаар зөвлөмж хүргүүлэх, сургалт зохион байгуулах.</p>	<p>-2 дугаар улиралд</p>	<p>ХААХ/ МТХ</p>
--	---	--	--------------------------	------------------

\* \* \*